



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/41

Баян-Овоо сум

Үндсэн хөрөнгө акталж, устгах
ажлын хэсгийг томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоол (Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам)-ын 6.2.1 дэх хэсэг, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 335 нэр төрлийн 2138 ширхэг 24,911,514.80 (хорин дөрвөн сая есөн зуун арван нэгэн мянга таван зуун арван дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэтэй үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг акталж, устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганцэцэг

Номын санч

Гишүүд: Ө.Цэлхаасүрэн

Сантехникч, мужаан

Ж.Уранчимэг

Дотуур байрын жижүүр

Ө.Бадамцэцэг

Дотуур байрын жижүүр

Нарийн бичгийн дарга: Т.Хүрэлтогоо

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүн

2. Үндсэн хөрөнгийг акталж, устгах ажлыг холбогдох хууль журмын дагуу 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулж, устгал хийсэн тухай акт үйлдэн тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганцэцэг)-т, нарийн бичгийн дарга (Т.Хүрэлтогоо) нарт даалгасугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн дарга (Г.Энхсүвд)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ч.БОЛОРМАА